

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ГАЗАРЗҮЙ, ГЕОЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН



МОНГОЛ ОРНЫ ГАЗАРЗҮЙ-ГЕОЭКОЛОГИЙН АСУУДАЛ

№40

Улаанбаатар 2019

МАЛЧДЫН НООЛУУРАА ЗАХ ЗЭЭЛД БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭХ СУУРЬ ТОГТОЛЦОО, ТҮҮНД УЧРАХ БЭРХШЭЭЛ

Ц.Солонго* • Б.Батхишиг** • Б.Цацралт***

*ШУА-ийн Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн
Газрын нөөц, газар ашиглалтын салбарын ЭША

**Нутгийн үйлс ба ухаан ТББ

***Нутаг академи ТББ

SUPPLY SYSTEM AND CURRENT CHALLENGES OF THE CASHMERE MARKET FOR HERDERS

Ts.Solongo • B.Batkhishig • B.Tsatsralt

Abstract

Today, cashmere is the most expensive in Mongolia's raw material market, and very large in the income of herder households. The cashmere industry consists of herders, cashmere traders and processing factories. Factors that negatively affect cashmere sales are that cashmere quality and standards do not compatible to international standards. It is necessary to investigate the current situation in relation to the cashmere market and prepare cashmere for herders' markets and economic conditions. The primary basis of large trade networks to meet the needs and demands of foreign markets is from herders. In other words, the price of cashmere in the cashmere market is the most beneficial towards herders. Herders sell their products to markets for their livelihoods. In recent years, cashmere products have become the highest yielding animal products. Due to the high price of cashmere, income derived from cashmere has grown significantly as a portion of herder households' income. There is a pressing need to study the situation in the market economy where herders are involved in cashmere preparation and the relationship with the cashmere market. We study the basis of cashmere supply to market and met with representatives of herders and who are facing difficulties in cashmere market. The study aims to identify the herders' cashmere market, the supply chain, the distribution of income and expenditure of herdsman, and the challenges of sustainable livelihoods and production.

Түлхүүр үгс

ноолуур бэлтгэн нийлүүлж буй тогтолцоо • малчин өрхийн өрхийн орлого • зарлага • тулгарч буй бэрхшээл

Оршил

Манай улс дэлхийн ноолуурын зах зээлд хоёр дахь том үйлдвэрлэгч юм. Ноолуурын чиглэлийн ямааг Монгол, БНХАУ, БНЭУ, ОХУ, Иран, Афганистан, зэрэг орнууд үржүүлж байгаагаас түүхий эдийн шинж чанараараа Монгол,

Хятадын ноолуур хамгийн сайнд тооцогддог. Монгол ямааны ноолуурын дундаж голч нь хамгийн нарийн буюу 14-16 микрон байдаг. Монгол ямааны самнасан ноолуурын уртлаг 38-43 мм байдаг бол Хятадынх 33-35 мм орчим байдаг. Афганистан, Энэтхэг, Иран зэрэг бусад орны ноолуур байгаль цаг уурын

нөхцөлөөсөө шалтгаалан Монгол ямааны ноолуураас 1.5-2.0 микроноор бүдүүн байдаг байна. Ийнхүү Монгол ямааны ноолуурын чанарын гол үзүүлэлт болох ширхгийн голч, уртлагаараа дэлхийн ноолуурын зах зээл дээр тэргүүлж байна [1].

Манай улсын ХАА-н экспортын голлох бүтээгдэхүүн болох мах, ноолуур, арьс ширний экспорт сүүлийн 20 жилд дунджаар нийт экспортын 11 хувийг эзэлж байгаагийн дийлэнх хувийг ноолуур бүрдүүлж байна [3]. Ноолуур нь тансаг зэрэглэлийн бараа бүтээгдэхүүний зах зээлийн гол бүрэлдэхүүн хэсэг бөгөөд дэлхийн нийт ноолуурын 85 хувь нь Хятад, Монголоос гаралтай [8]. Монгол улс 25 сая ямаатай бөгөөд жилд 9400 тонн ноолуурыг зах зээлд нийлүүлдэг. Энэ нь дэлхийн зах зээлийн 40 орчим хувийг эзлэх хэмжээ бөгөөд цаашдаа түүхий эдийг бүрэн боловсруулж нэмүү өртөг шингээн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж дэлхийн зах зээлд гаргах боломжтой юм.

Гадаад зах зээлийн эрэлт, хэрэгцээг хангах анхдагч суурь нь малчны хотоос эхлэлтэй. Өөрөөр хэлбэл, ноолуурын зах зээлийн үнийн өсөлт хөдлөл зүйн ашиг хүртэгч нь малчид бөгөөд малынхаа бүтээгдэхүүн ашиг шимийг зах зээлд борлуулж амьжиргаагаа залгуулдаг. Сүүлийн жилүүдэд малын түүхий эдийн дотроос үнийн хувьд хамгийн өндөр байгаа бүтээгдэхүүн нь ноолуур бөгөөд

ноолуураас олж буй орлого малчин өрхийн орлогод жинтэй байр суурийг эзэлж байна. Малчдын зах зээлийн эдийн засгийн нөхцөл байдалд ноолуур бэлтгэх, ноолуурын зах зээлд холбогдох харилцааг судлах зайлшгүй шаардлага бий болж байна.

Энэхүү судалгаагаар малчдын ноолуурын зах зээлд хүргэх сүлжээ, бэлтгэн нийлүүлж буй тогтолцоо, ноолуурын худалдаанаас малчин өрхийн орлого, зарлагын хуваарилалт, тогтвортой амьжиргаа ба үйлдвэрлэлд тулгарч буй бэрхшээлийг илрүүлэхийг зорилгоо. Бид Монгол улсад 2015 оноос хэрэгжиж эхэлсэн SFA (Sustainable Fibre Alliance) буюу “Монголын Тогтвортой ноос ноолуур эвсэл” төслийн хүрээнд нийт 2 аймгийн 8 сумын 43 хоршооны 286 өрх ба зорилтот бүлгийн хэмжээнд 51 фокус ярилцлагыг цуглуулсан.

Судалгаа явуулсан газар нутаг

Өмнөговь аймгийн Ханхонгор, Номгон, Хүрмэн, Баяндалай болон Баянхонгор аймгийн Баацагаан, Бууцагаан, Жинст, Хүрээмарал сумдад хээрийн судалгаа явуулав. Судалгаа явуулсан сумд нь манай улсын эдийн засгийн Төвийн болон Хангайн бүсэд хамаардаг бөгөөд эдгээр бүсийн голлох тулгуур нь ХАА болон Аж үйлдвэр, тэр дундаа мал аж ахуй, уул уурхайн олборлох үйлдвэрлэл түлхүү хөгжсөн байна.



1 дүгээр бүдүүвч. Судалгаа явуулсан сумд

Судалгааны аргазүй

Судалгаа явуулах зорилтод бүлгүүдийн хэмжээнд фокус бүлгийн ярилцлага авав. Зорилтод бүлгийг дараах байдлаар бүлэглэсэн болно: Үүнд:

- Орон нутгийн түвшний шийдвэр гаргагч
- Бүлгийн сонирхлыг төлөөлөгч (хоршооны дарга)
- Түүвэр малчин

Эдгээр ярилцлага нь малчдын ноолуурын зах зээлд хүргэх сүлжээ болон бэлтгэн нийлүүлж буй тогтолцоо, ноолуурын худалдаанаас малчин өрхийн олж буй орлого, зарлагын хуваарилалт, тогтвортой амьжиргаа ба өрхийн үйлдвэрлэлд тулгарч буй бэрхшээлийг тодорхойлоход суурь мэдээлэл болж өгсөн.

Өрхийн түвшний ноолуурын үйлдвэрлэлийн судалгааг түүвэр санал асуулгын аргаар хийж, дэвшүүлсэн таамаглалын баталгаажуулалтад дараах асуудлуудыг хамааруулан тооцов. Үүнд:

1. Малчдын ноолуураа зах зээлд нийлүүлж буй тогтолцоог судлан, тулгарч буй бэрхшээлийг илрүүлэх;
2. Малчин өрхийн МАА-н орлого, зарлагын төрлийг тодорхойлох;

Үр дүн

Манай улс эртнээс 5 хошуу малыг гаршуулан тэжээхдээ, бүс нутгийн онцлогт тохируулан өсгөсөөр ирсэн. Судалгаанд хамрагдсан сумд нь Монгол орны өмнөд болон баруун өмнөд хэсгийн цөлийн бүсэд хамаардаг ба тэмээ, ямаанд илүү зохимжит экологийн нөхцөлтэй учир энэхүү 2 төрлийг түлхүү өсгөж иржээ.

Ноолуурын салбарын харилцаа нь малчид, ноолуурын наймаа эрхлэгчид, боловсруулах үйлдвэрүүд, дамжуулан экспортлогч, бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, эцсийн бүтээгдэхүүн хэрэглэгч ба тэдгээрийн дотоод хэлхээгээр тодорхойлогдоно. Манай улсын хувьд 1990-ээд оноос мал аж ахуйн гаралтай түүхий эдийн бэлтгэлийн төвлөрсөн систем задарч одоогийн байдлаар оновчтой тогтолцоо бий болоогүй байгаа нь ноолуур бэлтгэн нийлүүлэх болон ноолуурын чанарт сөргөөр нөлөөлж байгааг зарим судалгаа харуулсан байдаг [1].

Малчдын ноолуур бэлтгэх, зах зээлд нийлүүлэх тогтолцоо нь хамгийн энгийн эдийн засгийн харилцаагаар

тодорхойлогдоно. Үндсэндээ энэ нь малчны хотноос орон нутгийн зах зээлд холбох “ченж” эсвэл хоршоод хоорондын харилцаа юм. Гэхдээ илүү өргөн

хүрээнд Монголын ноолуурын дотоод харилцаа ба түүний өртгийг дамжуулан экспортлогчид буюу гадны тоглогчид тогтоодог.




2 дугаар бүдүүвч. Ноолуурын зах зээлийн өнөөгийн тогтолцоо

Ноолуур борлуулалтын шатанд бэлтгэгч, зуучлагч, хэрэглэгчдийн хоорондын харилцаа холбоо сул, оролцогч талуудын ашиг сонирхол харилцан адилгүй байна. Дэлхийн ноолуурын зах зээл болон үнэд Монгол улс нөлөөлж чаддаггүйн адил дотоодын ноолуурын зах дээр түүхий эд бэлтгэн нийлүүлэгч малчдын хувьд ноолуурын үнийг тодорхойлоход оролцох боломж хязгаарлагдмал байна. Учир нь үнийн харилцаа экспортлогч ба дотоод зуучлагч нарын ашиг сонирхолд суурилдаг, харин малчид шууд гэрээлэгчтэй тэр бүр харьцдаггүй учир тэдгээрийн сонирхол үнэ тогтоох хэлэлцээрт тусгалаа олж чаддаггүй [7].

Малчин өрхийн үйлдвэрлэл ба өрхийн орлого, зарлага

Малчин өрхийн орлогыг МАА-н, МАА-н бус гэж ангилна. МАА-н бус орлогод тэтгэвэр, тэтгэмж, ажлын хөлс г.м. шууд мөнгөн орлого багтах бол МАА-н орлого нь малаас гарах түүхий эд, ашиг шимийн бүтцээс хамаараад олон янз задарна. Энэхүү судалгааны хүрээнд бид МАА-гаас олох өрхийн орлого, зарлагад ноолуур үйлдвэрлэлийн эзлэх хувийг тодорхойлохыг зорив.


Судалгаанд хамрагдсан өрхүүдийн МАА-н бүтээгдэхүүнээс олох орлогыг эзлэх хувиар нь эрэмбэлж үзэхэд орлогын дийлэнх хувь нь ноолуур үйлдвэрлэл ба борлуулалтаас олсон орлого байна.



1 дүгээр тахирмаг. МАА-н орлогын төрөл, хэмжээ

Судалгаанд хамрагдсан сумын малчдын 1 жилийн МАА-н орлогыг сум тус бүрээр авч үзэхэд малчин өрхийн нийт орлогод ноолуураас олж буй орлого хамгийн өндөр хувийг эзэлж байна (1-р тахирмаг). Аймгаар нь авч үзэхэд

Өмнөговь аймгийн судалгаанд хамрагдсан өрхийн ноолуурын орлого Баянхонгор аймгийнхаас өндөр байна. Мөн малчдын өрхийн орлогод хонь, тэмээний ноос борлуулснаас олж буй орлого ноолуурын дараа мөн өндөр байна.



2 дугаар тахирмаг. Малын тооноос хамаарсан МАА-н бүтээгдэхүүний орлогын хэмжээ

Өрхийн МАА-н орлогод малын аль бүтээгдэхүүнээс хамгийн их орлого олж байгааг авч үзэхэд малын тооноос үл хамааран ноолуураас олж буй орлого хамгийн өндөр хувийг эзэлж байна. Малчин өрхийн орлогын хэмжээг малын тооноос хамааруулан авч үзэхэд 300 хүртэл малтай өрхийн зөвхөн ноолуураас олж буй жилийн орлого дунджаар 5 сая хүртэлх төгрөг байгаа бол 500-аас дээш малтай өрхүүдийн ноолуурын орлого 5 ба түүнээс дээш сая төгрөг байна.

Япон улсын судлаач Ай Маекавагийн Монголд хийсэн судалгаагаар орлогын задаргаанд эзэлж буй жингээс хамааруулан малчид 5 хошуу малын алийг нь илүү өсгөх талаар бие даан шийдвэр гаргах эрхийг эдэлж байна. Түүний тодорхойлсноор ноолуур нь бусад малын түүхий эдийг бодвол хөнгөн жинтэй, таваарлаг, зах зээлд нэвтрэх

чадвар өндөртэй, дотоодод болон олон улсад үйлдвэрийн үнэтэй түүхий эд болдог зэргээс хамааран зах зээлийн эргэлт ихтэй МАА-н бүтээгдэхүүн болж байгаа аж [6]. Иймээс олон тооны судалгааны нэгэн адил ноолуур юуны түрүүнд малчин өрхийн амьжиргааны гол эх үүсвэр, хөдөөгийн тогтвортой байдлын нэг гол тулгуур бүтээгдэхүүн болж байна.


Зардал гэдэг нь үйлдвэрлэж байгаа бараа болон бүтээгдэхүүнийг бэлтгэн борлуулахад гарсан зардлыг хэлдэг. Хэдийгээр малчид ямааны аж ахуй эрхлэн ноолуур бэлтгэж зах зээлд нийлүүлэхэд жилд нэг удаа хавар ноолуураа самнах, самнасан ноолуураа зарах төдий харагдавч энэ нь угтаа ноолуурын ямааг өсгөн тэжээх, арчлахаас эхлээд бүхий л үйл явц багтана. Ямааны аж ахуй эрхлэхэд гарах зардлуудыг дараах байдлаар ангилж үзэв.

1 дүгээр хүснэгт. Ямааны аж ахуй эрхлэхэд гардаг зардлын төрөл

Үйлдвэрлэлийн зардал		Үйлдвэрлэлийн бус зардал	
Үйлдвэрлэлийн шууд зардал	Үйлдвэрлэлийн нэмэлт зардал	Удирдлагын зардал	Борлуулалтын зардал
- Үржлийн мал авах - Хадлан, тэжээл, гар тэжээл бэлтгэх - Мал эмнэлгийн үйлчилгээ - Ямаа самнах, ангилах зардал	- Өвөлжөө барих, засварлах - Худаг гаргах, засварлах - Тоног төхөөрөмж, машин техник авах, түрээслэх - Цалин, урамшуулал - Нүүдэл хийх, - Тээвэр, шатахуун	- Малын даатгал - Сургалтын зардал - Цалин, урамшуулал - Хүүгийн зардал	- Бараа материал авах - Хадгалалт - Тээвэрлэлт - Савлах - Хүргэлтийн зардал

Судалгаанд хамрагдсан өрхүүдийн 1 жилийн зардлыг санал асуулгаар асууж, өрхийн түвшинд ноолуурын үйлдвэрлэл


болоод өрхийн хэрэгцээнд зарцуулагдаж буй бусад зардлуудыг гаргав (3-р тахирмаг).



3 дугаар тахирмаг. Малчин өрхийн 1 жилийн зардал (дунджаар, ₮)

Судалгаанаас малчин өрхийн зарцуулалтыг нийт судалгаанд хамрагдсан 286 өрхийн өгөгдлөөс эрэмбэлэн, нэг жилд хамгийн их зардал гаргадаг эхний 5 үзүүлэлтийг авч үзвэл: мотоцикл авах, зээлийн төлбөр, хүнс болон хувцсаа авах, оюутан сурагчдын сургалтын төлбөр зэрэг зардлууд хамгийн өндөр байна. (3-р тахирмаг)

Малчдад санхүүгийн хэрэгцээ хавар (цагаан сар, малын өвс тэжээл авах гэх мэт), намар (хүүхдүүдийнхээ хичээлийн хэрэгслийг бэлдэх, оюутны сургалтын төлбөр төлөх, хадлан, тэжээл бэлдэх) хамгийн өндөр байдаг бол жилийн хамгийн их орлоготой байх үе нь хавар ноолуураас олох орлого болох нь судалгаагаар тогтоогдов.



4-р тахирмаг. Ноолуураа борлуулсан газар

Судалгаанд хамрагдсан малчдаас ноолуураа хаана худалддагийг тодруулахад, 2017 оны байдлаар хамгийн их буюу 59 хувь нь сумандаа, 26 хувь нь аймагт, 12 хувь нь гэрээсээ ноолуураа борлуулжээ (4-р тахирмаг). Тэд ноолуураа сум, аймгийн төвд байдаг наймаа эрхэлдэг хүнсний дэлгүүрийн зээд болон ноолуур байнга авдаг “ченж”-үүдэд өгдөг бөгөөд малчид тэднээс хавар цагаан сар тэмдэглэх, малдаа өвс тэжээл авах болон бусад шаардлагаар, бэлэн мөнгө болон хүнс бараа материалыг зээлж аваад, эргээд ноолуураа тушаах эсвэл ноолуураа зарсан мөнгөөрөө зээлээ төлж байна.

Улаанбаатар хотын “Цайз” зах нь манай улсын түүхий эдийн төвлөрсөн ганц томоохон зах бөгөөд орон нутаг дахь бүсийн үйлдвэрлэлийн төвүүдээс 600-1000 км-ийн зайд оршиж байна. Ийнхүү малчид ноолуураа гэрээсээ эсвэл орон нутагтаа ченжүүдэд борлуулах нь нийслэлд худалдан авч буй үнээс 10-45 хувиар хямд байгаа нь малчдыг ихээр хохироож байна [5].

Ноолуурын үйлдвэрлэл ба борлуулалтын түвшинд малчдад тулгарах бэрхшээл

Малчдаас авсан асуулгад ноолуур борлуулахад тулгарч буй бэрхшээлийг дараах байдлаар тодорхойллоо. Үүнд:

- ХАА-н бүтээгдэхүүн болон малын

түүхий эдийн үнэ зах зээлд хямд;

- Ченжийн дамжлагагүйгээр шууд үйлдвэртэй холбогдох боломж байдаггүй;
- Малчдад хоршоогоор дамжуулсан нэгдсэн зохион байгуулалт шаардлагатай;
- Хувь хүнд ноолуураа борлуулахад ноолуурын зөрүү өгдөггүй;
- Зах зээлээс алслагдсан байдал;
- Зах зээлийн үнэ, ханшийн мэдээлэл дутмаг;

Ноолуур борлуулах талаар хүчин төгөлдөр ямар нэг гэрээ хэлэлцээр байхгүй, бүх боловсруулаагүй ноолуурын 80 хувийг айл өрхөөс шууд худалдан авч байгаа нь үйлдвэрлэлийн салбарт бүтээгдэхүүн худалдан авах босоо тогтолцоо нэвтрүүлэх оролдлогод саад болж байна [5].

Хэлэлцүүлэг

Малчин өрхийн орлогын хэмжээг малын тооноос хамааруулан авч үзэхэд 300 хүртэл малтай өрхийн зөвхөн ноолуураас олж буй жилийн орлого дунджаар 5 сая төгрөг байгаа бол 500-аас дээш малтай өрхүүдийн ноолуурын орлого 5 ба түүнээс дээш сая төгрөг байна. Өрхийн орлогод малын аль бүтээгдэхүүнээс олж буй орлого хамгийн өндөр байгааг малын тооноос хамааруулж үзэхэд өрхийн МАА-н

ноолуур эвсэл” болон шүүмж өгч, үнэтэй зөвлөгөө өгсөн төслийн удирдагч, доктор (Ph.D) Б.Батхишиг, ШУА-ийн Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн Цөлжилтийн судалгааны салбарын дарга, доктор (Ph.D) Н.Мандах нарт талархал илэрхийлье.

Ашигласан хэвлэл:

1. Отгондорж Б. 2001. Ноолуурын салбарын судалгаа, МБХолбоо, УБ
2. МУ-ын Гаалийн Ерөнхий Газрын тайлан. 2014. УБ
3. Мөнхгэрэл Ж., Батжаргал Ж., Нармандах Б. 2014. Ноолуурын үнэ түүний эдийн засагт үзүүлэх нөлөөллийг судлах, ноолууран эдлэлийн борлуулалтыг нэмэгдүүлэх нь, тайлан, УБ.
4. Түвшинтөгс Б., Бумчимэг Г., Эрдэнэбулга Д. 2015. ХАА-н салбарын өрсөлдөх чадвар ба орон нутгийн хүн амын амьжиргааны тайлан, Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн, УБ
5. Батхишиг Б., Алтанзул Ц., Цацралт Б., 2017. Ноолуур бэлтгэж буй хоршоодын санхүүгийн хэрэгцээ, шаардлага, тайлан, FA, Монголын тогтвортой ноос ноолуур эвсэл, УБ,
6. Ай Маекава. 2012. Зах зээлийн эдийн засгийн шилжилтийн дараах Монголын ноолуурын үнэ өртөг, Монголын нүүдлийн мал аж ахуй экосистемийн сүлжээ, Японы Киото хот дахь Хүмүүнлэг ба Байгалийн Судалгааны Хүрээлэн, УБ, х.330-345.
7. Ноолуурын үйлдвэрлэлийн өртөг нэмэгдэх үйл явц, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн оролцоо, тайлан 2004. НҮБ-ын Эмэгтэйчүүдийн Хөгжлийн Сан, УБ,
8. Haekyung Y., Sunyoung K., Svetlana B. 2014 Evaluation of Mongolian Cashmere Clothing: Comparison between Mongolian Workers and Foreign Tourists, R. Salerno-Kochan (ed.) Commodity Science in Research and Practice – Non-food products' quality and innovations, Polish Society of Commodity Science, Cracow,